



Төрийн албаны зөвлөлийн  
2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн  
645 дугаар тогтоолын 27 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙПОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан  
огноо

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Сангийн яам

Санхүүгийн бодлогын газрын  
Өрийн удирдлагын хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Гадаад зах зээл, харилцаа, олон талт зээл  
хариуцсан шинжээч

Ахлах түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Монгол Улсын Сангийн яам, Чингэлтэй дүүрэг,  
Засгийн газрын II байр Д корпус, С.Данзаны  
гудамж Улаанбаатар 15160

Хөдөлмөрийн нэхцэл:

Онцгой нэхцэл:

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Гадаадын хөрөнгө оруулагчид, зах зээлийн оролцогчидтой хамтран ажиллах, шинээр гадаад зээллэг хийх үйл ажиллагааг зохион байгуулах, гадаад өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гадаад зах зээлийн талаар судалгаа шинжилгээ хийх, Засгийн газрын гадаад зээлийн хэлэлцээрийг байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

**Албан тушаалын зорилт:**

- Гадаадын хөрөнгө оруулагчид, зах зээлийн оролцогчид бусад байгууллага болон зээлдэгчидтэй өрийн удирдлагын чиглэлээр хамтран ажиллах, гадаад үнэт цаас арилжаалах үйл ажиллагааг зохион байгуулах, гадаад зах зээлээс синдикат зээл авах, своп хэлэлцээр хийх зэрэг өрийн зохицуулалтын арга хэрэгслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, шинээр гадаад зээлээг хийх үйл ажиллагааг зохион байгуулах, гадаад өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гадаад зах зээлийн талаар судалгаа шинжилгээ хийх, Засгийн газрын гадаад зээлийн хэлэлцээрийг байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх,
- Олон улсын зах зээлийн талаар судалгаа хийж, танилцуулга бэлтгэх, өрийн зохицуулалтын хүрээнд шинээр нэвтрүүлэх боломжтой гадаад өрийн хэрэгсэл болон гадаад зах зээлийн болзошгүй эрсдэл, бусад хүчин зүйлийн талаар судалгаа шинжилгээ хийх.
- Засгийн газрын гадаад зээл, хэлэлцээр байгуулах, олон талт түншүүдийн санхүүжилтээр хэрэгжих зээлийн төслийн судалгаа бодлогын зөвлөгөө, боловсруулалт, дүн шинжилгээ хийх.
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Хөрөнгө оруулагчид, олон улсын зах зээлийн оролцогчидтой уулзалтыг зохион байгуулах, гэрээ хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулах, донор, хөрөнгө оруулагчид, зах зээлийн оролцогчдод шаардлагатай мэдээллийг бэлтгэн мэдээлэх;</p>	Холбогдох хууль, журамд заасан хугацаанд багтаан нэгтгүүлсэн эсэх	Г, Х
	<p>1.2. Гадаад зах зээлд үнэт цаас гаргах, шинээр гадаад зээлээг хийх, гадаад өрийн болон бусад өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналыг боловсруулан танилцуулж, гэрээ хэлэлцээр байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах</p>	Өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналыг боловсруулж, гэрээ хэлэлцээр байгуулсан байх	Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1. Гадаад зээл зээлийн судалгаа, гадаад зах зээлд үйл ажиллагаа явуулснаар үүсэж болзошгүй эрсдэл болон бусад хүчин зүйлийн талаар судалга хийж санал боловсруулах</p> <p>2.2. Засгийн газрын үнэт цаасыг гадаад зах зээлд арилжаалах болон таатай нөхцөл байдлыг өдийн засгийн үр өгөөжтэй уялдуулан судлах.</p>	Холбогдох хууль, журамд заасан хугацаанд багтаан гаргаж нэгтгүүлсэн байх	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1. Засгийн газрын гадаад зээл, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн зээлийн хэлэлцээр байгуулах, бэлтгэл ажлыг хангах, хяналт тавих</p> <p>3.2. Олон улсын банк, олон улсын санхүүгийн байгууллагын зээлээр хэрэгжих төсөл арга хэмжээний дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах, хянах.</p>	<p>Олон талт түншүүдтэй байгуулсан зээлийн хэлэлцээрийн тоо</p> <p>Олон улсын санхүүгийн байгууллагын зээлээр хэрэгжих төсөл арга хэмжээний</p>	Г, Х



		төсвийн төслийг боловсруулсан байх	
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Хууль хяналтын болон хөндлөнгийн аудитын байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, тайлбар авах хүснэгтийн хүрээнд шаардлагатай нэмэлт мэдээ, мэдээлэл, материалыг гаргаж, хүргүүлэх;	Мэдээллийг үнэн зөв гарган, боловсруулсан байх	Г
	4.2.Холбогдох хурал, уулзалтад шаардлагатай илтгэл, танилцуулга, ярианы сэдэв бэлтгэх, хурал уулзалтыг зохион байгуулах;	Холбогдох хууль журамд нийцсэн байх	Г
	4.3.Нэгжийн эрхлэх асуудлаар Улсын их хурал, Засгийн газар, яамны удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтийг тайланг гаргуулан тайлагнах;	Холбогдох хууль журамд нийцсэн байх	Г
	4.4.Өөрийн хариуцсан ажилтай холбоотой болон цаг үеийн асуудлаар ирсэн албан бичиг, иргэд байгууллагын санал, гомдол, өргөдөлд хууль, журамд нийцүүлэн хариу бэлтгэн, удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;	Холбогдох дүрэм зааврын хүрээнд боловсруулсан байх	Г
	4.5.Тооцоо нийлсэн болон үлдэгдэл тулган баталгаажуулсан акт, харилцсан бичиг зэрэг бичиг баримтыг эмхэлж цэгцлэн, архивд хүлээлгэн өгөх;	Холбогдох дүрэм зааврын хүрээнд боловсруулсан байх	Г
	4.6. Хууль, тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд холбогдох байгууллагыг албан ёсны статистик мэдээллээр хангах, статистик мэдээллийг тархаах.	Холбогдох хууль журамд нийцсэн байх	Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	- Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	- Санхүү /041201/; - Эдийн засаг /0311/; - Нягтлан бодох бүртгэл /041101/; - Эрх зүй /0421/; - Бизнесийн удирдлага /041301,041307/	
Мэргэшил	- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссен байх.	
Туршлага	- Төрийн албанад 6 жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - Судалгааны арга зүйн мэдлэгтэй.
	Асуудал шийдвэрлэх	- Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах.
	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонгой хуваалцаж хамтран ажиллах; - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	- Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар

**IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:  
Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга


<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>  Ахлах мэргэжилтэн-2 Мэргэжилтэн-2  Нийт -4	<u>Бусад харилцах субъект</u>  1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын газар, хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс; 2. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан; 3. Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.
---	---

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>  Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга .....  Б.СҮХ-ОЧИР	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зэвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>  ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВДӨЛ ШИЙДВЭРИЙН ОГНОО:  Дугаар: 
---	---


**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**Байгууллагын нэр:

САНГИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:  2022.12.30Дугаар: 

(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

2022 оны 12 дугаар сарын  30-ны өдөр